

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Данзанчойен	Дугаар	L285
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хядагийн хурал	Сүм хийдийн дугаар	ХӨМХ 042
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Хядагийн хурал

Мөнхбат: За өнөөдөр 2007 оны 6 сарын 10-ны өдөр.Манай судалгааны баг Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын Гандандаржаалин хийд дээр судалгааны ажлаа үргэлжлүүлж байна.Тэгэхээр хуучнаар засагт хан аймгийн Ахай бэйсийн хошууны нутаг буюу өнөөдрийн Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын нутаг дахь байсан буддын шашны хүрээ хийдүүдийн цуврал жагсаалтанд одоо Бямбын Ренчин гуайн судалж мэдсэнээр бичигдсэн Хядагийн хурлын тухай дараах асуултыг тус Мөрөн сумын өндөр настан нэгдүгээр багийн харъяат Данзанчойен гуайгаас лавлаж тодруулсан юм аа.Ингээд Данзанчойен гуай дашрамд хэлэхэд эдүгээ тус хийдийн жас сангийн даамлаар ингэж ажилладаг ийм хүн байна.За тэгэхээр танд дараах асуултыг тавъя.Тэгэхээр Засагт хан аймгийн Ахай бэйсийн хошууны шашин номын газрын нэгээхэн хэсэг болох Хядагийн хурал өнөөдөр Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Арбулаг, Мөрөн сумын одоо хилийн дээс уулзвар Хядагийн голын орчим ингэж байрладаг юм байна.Тэгэхээр та одоо Хядагийн хурлын ямар хэдэн дугантай байсан, шашин номын ямар үйл ажиллагаа явуулж байсан, за мөн шашны ямар урсгал чиглэлийн ийм одоо хурал номын газар байсан бэ, энэ талаар товчхон хэлж өгнө үү?

Данзанчойен: Энэ хүрээнд байхдаа энэ Хядагийн голын хүрээ бол зодын хүрээ байсан юм гэнэ лээ.Зодын хүрээ байхдаа тавь жараад ламтай, яахав дөрвөн дугантай ийм хүрээ байсан гэж улсууд ярьдаг юм байна лээ. Тэгээд одоо бас уг нь энэ Мөрөнгийнхөө төв дээр байсан юм гэнэ лээ.Тэгээд манай энэ хүрээний сахиус бас тиймэрхүү, зодын талын юуг хүлээж авах таарамж муутай болоод. Тэгээд тасарч энэнээсээ тасарч Хядагийн голд байгуулагдсан гэж хууччуул ярьдаг байсан.

Мөнхбат: Тэгэхээр энэ зод гэсэн энэ шашин номын нэр томъёог одоо яг орчин цагийн утгаар тайлбарлавал та одоо юу гэж тайлбарлаж өгөх вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Данзанчойен: Энэ тал бол одоо яахав дээ, мэргэ төлөг талыг л голлосон. Одоо өөрөөр хэлбэл одоо харын талын л юм уу даа. Тэр талыг л одоо голлосон тийм л хэсэг улсууд, мэрэг төлөг бүүлгадаг. Тэгээд л тэр зод гэдэг чинь одоо энэ янз бүгдийн юмнаас зайлуулсан, гай барцад...

Мөнхбат: Тэгэхээр одоо энэ Хядагийн хурлын тэр дөрөв, тавн дуганы ул мөр туурь ямархуу байдалтай байна вэ?

Данзанчойен: Энд яахав нэг хэдэн цагаан чулуу байдаг юм аа. Тэгээд нэг тойрсон гурав дөрвөн хиргисүүр байгаа. Аа дөрвөн талд нь одоо чухам юуны одоо нэг тийм чулуу байдаг юм. За тийм суварга байсан юм уу, чухам одоо тийм янз бүрийн юм нь байсан юм уу. Тэгээд тэрэн дээр бол одоо зарим нэгэн улсууд, одоо нааш цааш нь явж байхад чинь тэр чулуу овоолчихсон. Зарим дээр нь ингээд мод босгочихсон, хадаг энэ тэр уячихсан. Тийм, зарим нь бүр тийм овоорхуу юмтай байдаг. За тэр доод талд нь Хядагийн түрүүний рашаан гэж одоо бүр олон түмэн очдог, одоо элэг цесөнд сайн гээд. Тэрний овоог бол тахидаг, шүтдэг одоо ийм юмнууд ойр хавьд нь байгаа. Тэгээд тэр юу Мэргэний дөрөлж гээд наад талд нь байдаг. Цаад талд нь Буянтын гол гээд одоо нэг их том хөндий байгаа. Тэрний хойд талаар нь одоо буянтын ямар юм билээ, уулыг нь мартчихжээ. Тийм юмнууд байгаа, байдаг юм аа.

Мөнхбат: За энэ хүрээнд шавилж сууж байсан гэдэг юм уу, одоо хурал ном үйлдэж байсан лам хуваргууд, шавилж сууж байсан банди нар бол өнөөдөр мэдээж одоо нэгэнт байхгүй байгаа нь ойлгомжтой. Тэгэхээр одоо зүгээр ихэс дээдэс багш, хөгшчүүлийнхээ ярианаас улбаалан сонсоод энэ хүрээ ямар шүтээнтэй байсан юм бол, одоо ямар сахиустай байсан юм бол за энэ хүрээний одоо мөхөл 1937, 1938 оны тэр хар жилүүдэд энэ хүрээ одоо ямар байдалтай байсан юм бол, байж байгаад дууссан юм бол, энэ талаар одоо таны мэдээллэх зүйл?

Данзанчойен: За тэр талаар бол надад ёстой дуулж мэдсэн юм багахан даа, чухам ямар байсан юм. Гэхдээ тэр гучин долоо, найман онд л устахад нь тэр үеэр л байсан. Тэгээд тэрнээс хойно одоо надыг нааш цаашаа багад явж байхад нэг тийм, одоо нэг дугана тийм тал дээвэртэй дуган байсан. Нэг тийм юм харагддаг байсан. Тэгээд сүүлийн үед чухам одоо энэ лүү л ачсан юм уу, энэ Арбулаг руу ачсан юм уу, амьтан хүн нутгийн улсууд тэгээд тарааж авсан юм уу тэгээд одоо ер нь тэндээс хаана ч үгүй болсон газар юм даа.

Мөнхбат: За баярлалаа. Таны өгсөн мэдээлэл монголын сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа. Танд баярлалаа.